




ЛэндМН ББСБ ХК-ийн 2019 оны 2 дугаар улирлын
САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН:

2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ
ӨНГӨРСӨН ОНЫ ЦЭВЭР АШИГААС
ДАВСАН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ГАРЛАА.



2019 оны II дугаар улиралд “ЛэндМН ББСБ” ХК нь өөрийн үндсэн үйлчилгээ болох Цахим зээлийн болон төлбөр тооцооны үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тус зорилгын хүрээнд хэрэглэгчдийн өдөр тутам тогтмол ашигладаг олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг Lendmn аппликейшн дээрээс хялбараар авч, Лэнд хэтэвчээр төлбөр төлөх боломжуудыг нэвтрүүлээ.

Мөн зээлийн үйлчилгээг дараагийн түвшинд хүргэх, зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах судалгаа хөгжүүлэлтийн ажлуудыг эхлүүлээ.


Компанийн нийт хувьцаа эзэмшигч та бүхэнд компанийн 2-р улирлын санхүү үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.




ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн зээлийн бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлтүүдийг өнгөрсөн улирлын тоон үзүүлэлттэй харьцуулбал Гэрээт харилцагчийн тоо 14%, Олгосон зээлийн тоо 20%, Олгосон зээлийн дүн 24%, Зээлийн багц 20%-иар тус тус өслөө.


Гэрээт харилцагчид,
өссөн дүнгээр
(мянган харилцагч)




Олгосон зээлийн тоо
(мянган зээл)



Олгосон зээл
(Тэрбум төгрөг)



Зээлийн багц
(Тэрбум төгрөг)



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

MNT'000	2019 Q1	2019 H1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,820,379.00	9,714,713.00
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	30,619,730.00	36,583,462.00
Бусад хөрөнгө	314,227.00	886,922.00
Үндсэн хөрөнгө	299,653.00	429,766.00
Биет бус хөрөнгө	376,376.00	365,382.00
Нийт хөрөнгө	33,430,365.00	47,980,245.00
Хаалттай бонд болон бусад зээлийн өглөг	17,605,235.00	20,167,781.00
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	500,452.00	11,706,219.00
Цахим хэтэвч - өглөг	593,371.00	941,324.00
Ногдол ашгийн өглөг	540,000.00	140,000.00
Богино хугацаат бусад өглөг	388,991.00	178,350.00
Нийт өр төлбөр	19,628,049.00	33,133,674.00
Хувьцаат капитал	10,814,206.91	10,548,120.89
Хуримтлагдсан ашиг	2,988,109.00	4,298,450.00
Нийт эздийн өмч	13,802,315.91	14,846,571.00
Нийт өр төлбөр болон эздийн өмч	33,430,364.91	47,980,245.00

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

MNT'000	2019 Q1	2019 H1
Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого	3,469,784.00	7,704,947.79
Хүүгийн зардал	- 572,618.00	- 1,667,803.94
Цэвэр орлого	2,897,166.00	6,037,143.85
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	- 269,025.00	- 628,636.79
Үйл ажилгааны цэвэр орлого	2,628,141.00	5,408,507.06
Удирдлагын болон ҮА зардал	- 823,044.00	- 1,726,008.93
Банк болон бусад системийн шимтгэлийн зардал	- 412,505.00	- 869,324.52
Нийт зардал	- 1,235,549.00	- 2,595,333.45
Татварын өмнөх ашиг	1,392,452.03	2,855,356.42
Татварын зардал	- 144,511.00	- 297,074.51
Цэвэр ашиг	1,247,941.03	2,558,281.91

ЗЭЭЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зээлийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан байдлаар

Өссөн дүнгээр	2018 Н1	FY 2018	2019Н1	Өсөлт
Гэрээт харилцагчид	55,084	94,375	137,532	150%
Гэрээт мерчантууд	-	2,224	3,238	NA
Хэтэвчээр хийсэн гүйлгээний тоо	-	90,327	305,648	NA
Нийт олгосон зээлийн тоо	367,973	849,957	1,705,279	363%
Нийт олгосон зээл (Тэрбум төг)	65.7	161.3	338.3	415%

Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн оны мөн үе болон өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулсан байдлаар


Тэрбум төг	2018 Н1	2019 Н1	Өсөлт	FY 2018	2019 Н1	Өсөлт
Зээлийн багц	10.3	36.8	257%	19.2	36.8	92%
Нийт эздийн өмч	12	14.8	23%	13.4	14.8	10%
Нийт хөрөнгө	14.1	48.0	240%	24.3	48	98%
Орлого	2.6	7.7	196%	7.0	7.7	10%
Цэвэр ашиг	1.2	2.6	117%	2.5	2.6	4%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН компанийн хувьцаа 2019 оын 6 сарын 28 өдрийн арилжаа буюу 2 дугаар улирлын төгсгөлд 64.97₮-ийн ханштайгаар хаагдаж Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжааг идэвхээрээ тэргүүлсээр байна.

БИРЖИЙН ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖААНЫ ДҮН (САЯ ТӨГРӨГ)

(2019 ОН 2-Р УЛИРАЛ)




● ЛЭНДМН ● АРД ДААТГАЛ ● АПУ ● ГОВЬ ● ТАВАН ТОЛГОЙ ● МОНГОЛ ШУУДАН ● МАНДАЛ ДААТГАЛ

Эх сурвалж: МХБ


БИРЖИЙН НИЙТ АРИЛЖСАН ХУВЬЦААНД ЭЗЛЭХ ХУВЬ

(2019 ОН 2-Р УЛИРАЛ)




БИРЖИЙН НИЙТ АРИЛЖААНЫ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

(2019 ОН 2-Р УЛИРАЛ)



● ЛЭНДМН ● АРД ДААТГАЛ ● АПУ ● ГОВЬ ● ТАВАН ТОЛГОЙ ● МОНГОЛ ШУУДАН ● МАНДАЛ ДААТГАЛ ● БУСАД

Эх сурвалж: МХБ



Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааны ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- ✓ "LendMN Open Platform"-ыг олон нийтэд танилцууллаа.
- ✓ Хэрэглэгч нэг аппликейшнээр олон төрлийн үйлчилгээ авах боломжтой боллоо.
- ✓ ЛэндМН-д онлайн дэлгүүр нээгдлээ.
- ✓ Лэндийн хямдралын купоноор бусдад бэлэг барих боломжтой боллоо.
- ✓ Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлж БНСУ болон Австрали улсуудаас мөнгө хүлээн авах боломжтой боллоо.
- ✓ Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ХАНДИВЫН СИСТЕМ нэвтрүүллээ.
- ✓ Playtime Music Festival 2019-ийн стратегийн түншээр хамтран ажиллалаа.

LENDMN OPEN PLATFORM

ЛэндМН ББСБ ХК нь 2019 оны 5 дугаар сард "LendMN OpenPlatform"-ыг зах зээлд танилцуулсан.

Уг нээлттэй платформыг LendMN аппликейшныг бүтээгч Анд Системс Тех ХХК хөгжүүлсэн бөгөөд тус платформ нь бүх хүнд нээлттэй. Хамтран ажиллах хүсэлтэй хэн бүхэн шинэ бизнес санаа, хөгжүүлсэн технологи, бүтээгдэхүүн үйлчилгээгээ зах зээлд таниулахыг хүсвэл 600,000 гаруй хэрэглэгчийн бааз суурьтай LendMN аппликейшнд "мини апп" хэлбэрээр байршуулах боломжтой технологийн шинэ шийдэл юм.

Цаашид хэтэвч хэрэглэгчдийн өдөр тутам ашигладаг үйлчилгээнүүдийг LendMN дотор нэвтрүүлж "Хүний хэрэглээ цөм бүрдсэн аппликейшн" болгохоор зорьж байна. Өнгөрсөн хугацаанд Хоол хүргэлт, хүнс хүргэлт, кино болон үзвэр үйлчилгээний тасалбар захиалга, хандив, нислэгийн тийз худалдан авах, даатгалын үйлчилгээ зэрэг 20 гаруй нэмэлт үйлчилгээг нэвтрүүлээд байна.




LendMN Open Platform


Хаан даатгал



Ticket.mn



Онлайн дэлгүүр



Номин даатгал



Geru



Ubcab



Эдгээр нэмэлт үйлчилгээнүүдийг ЛэндМН аппликейшнээс хамгийн хялбараар авч лэнд хэтэвчээр дамжуулан хийгдсэн гүйлгээний үнийн дүн 2.5 тэрбум төгрөгт хүрээд байна.

ЛЭНДИЙН КУПОНОО БЭЛЭГЛЭДЭГ БОЛЛОО.



КУПОН БЭЛЭГЛЭДЭГ БОЛЛОО

Таны хэрэгцээнд тохирсон хамгийн супер бүтээгдэхүүнүүдийг зөвхөн Лэндийн хямдралын купоноор худалдан борлуулдаг байсан бол худалдан авсан купоноо бусдад бэлэглэх, дотны хүмүүстээ шилжүүлж гэнэтийн бэлэг барих боломжтой боллоо.

Улирлын чанартай хамгийн сонирхолтой бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ Лэндийн хямдралын купонд нэгтгэж хамгийн олон хүнд хүргэх боломжийг бүх бизнес эрхлэгч байгууллага, хувь хүмүүст олгож байна.

ЛЭНДМН ОНЛАЙН ДЭЛГҮҮР

Хэрэглэгч та өөрийн цаг заваа хэмнэж өөрт хэрэгцээт худалдан авалтаа Lendmn аппликейшны Онлайн дэлгүүр цэсээр дамжуулан худалдан авч, өдрийн дотор хүссэн байршилдаа хүргүүлэн авах боломжтой боллоо.

ЛэндМН онлайн дэлгүүрийн үйлчилгээг үзүүлэгч Banana mall нь 1000 гаруй нэр төрлийн баталгаат бараа бүтээгдэхүүнүүдийг үндэсний үйлдвэрлэгч, албан ёсны борлуулагчаас нь таны гарт найдвартай хүргэж өгдгөөрөө онцлог юм.

- ✓ Хялбар, найдвартай төлбөрийн систем
- ✓ Цаг мөнгөө хэмнэх боломж
- ✓ Худалдан авалтаа хянах систем
- ✓ Дансны үлдэгдэлдээ санаа зовох хэрэггүй
- ✓ Баталгаат хүргэлт


banana
by lendmn





ЛЭНДЭЭР ХАНДИВЛАЯ

БЯЦХАН ХАНДИВ, ТОМ АЗ ЭСЭРТЭЙ



ЛЭНДЭЭР ХАНДИВЛАДАГ БОЛОО

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд өөрсдийн аппликейшн дээр хэрэглэгч хандив өгөх боломж бүхий платформыг нэвтрүүлээ. Нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж буй Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, нөгөө талаас хэрэглэгчдэд хандив өгөх илүү хялбар оновчтой шийдлийг санал болгож байгаа юм.



Хүүхдийн төв сувилал:
Өдөр өнжүүлэх өрөөг
Тохижуулах төсөл.



Азтай савар:
Амьтад ч жаргах эрхтэй



Ид шидийн орон 2 төсөл:
Тоглоомын талбай




Мод тарих аян:
Хүн бүхэнд цэвэр агаар

Ингэснээр тухайн хандивын зорилго, хэрэгцээ шаардлага, нийт цугларсан санхүүжилтын мэдээллийг хэрэглэгч ил тод мэдэх боломж бүрдээд байна.

ГАДААД МӨНГӨН ГҮЙВУУЛГА

ЛэндМН компани олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг албан ёсоор нэвтрүүлж Лондонд төвтэй Thunes компанитай хамтын ажиллагаагаа эхлүүлээ. Thunes компани нь дэлхий даяар 80 гаруй оронд 9000 гаруй компанийн төлбөрийн системтэй хамтарч ажилладаг салбарын томоохон тоглогчдын нэг бөгөөд Хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-аас 8 сая хүртэлх төгрөгийг ердөө 5 секундын дотор хүлээн авах боломжтой боллоо.



Хүлээн авагч нь зөвхөн ЛэндМН аппликейшний хэрэглэгчид байх бөгөөд БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэд энэхүү үйлчилгээг авахын тулд Napass аппликейшнийг суулгаж, тус улсын аль ч банкны дансыг холбож баталгаажуулснаар ашиглах боломжтой. Цаашид БНСУ-аас гадна АНУ, Япон, Европын орнууд зэрэг Монгол иргэдийн хамгийн их суурьшдаг орнуудад үйлчилгээг нээх юм.

Одоогоор Австрали улсаас мөнгөн гуйвуулга хүлээн авч эхлээд байна.



МӨНГӨН ГҮЙВУУЛГА
СОЛОНГОСООС МОНГОЛ РУУ
5-ХАН СЕКУНД

- ✓ ИЛҮҮ ХЯМД
- ✓ ИЛҮҮ ХЯЛБАР
- ✓ ИЛҮҮ ХУРДАН



PLAY
TIME
2019
MUSIC FESTIVAL
JULY/05-07

presented by



LENDMN

ЗАЛУУСЫН ХАМГИЙН ТОМ
ХӨГЖМИЙН НААДАМ "PLAYTIME"
ФЕСТИВАЛИЙН ТҮНШ БОЛОО



Хөгжим сонирхогч, дурлагч залуусын хүсэн хүлээдэг "Playtime" олон улсын хөгжмийн фестивалийн стратегийн түншээр ЛэндМН хамтран ажиллалаа. Хамтын ажиллагааны хүрээнд "Playtime" фестивалийн тасалбар борлуулалтыг ЛэндМН аппликейшнээр борлуулж хэрэглэгчдэд илүү хялбар шийдлийг санал болголоо.

3 өдрийн турш нийт 35 мянга гаруй залуус цугларсан тус фестивалийн төлбөр тооцоо, шилжүүлгийн үйлчилгээг ЛэндМН хэтэвчээр дамжуулан илүү хялбараар шийдлээ.

"Playtime" наадмын үеэр ЛэндМН-ий "Lendmn Loves Music" асарт сонирхолтой арга хэмжээнүүдийг зохион байгуулж өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчиддээ танилцууллаа.





КОМПАНИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БУЙ ЗЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Компани үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагаас эхлэн хүний ажил ажиллагааг технологийн тусламжтайгаар хөнгөвчилж, байгаль орчинд эерэг ээлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Байгаль орчинд үзүүлж буй эерэг нөлөөллийг тоон үзүүлэлтээр харуулбал:



Агаарын бохирдол Co2
1'023'167 кг

Нэг хүн зээлийн үйлчилгээ авахад дунджаар 5км замын хөдөлгөөнд оролцдог. Тэгвэл үүнийг ЛэндМН аппликейшн-р шийдсэнээр тээврийн хэрэгслээс ялгарах 1023тн нүүрс хүчлийн хий агаарт цацагдаж агаар бохирдуулахаас сэргийлэв



Мод аврав
2'558 ширхэг

Нэг удаагийн зээл олголтонд дунджаар 15 хуудас цаас зарцуулагддаг. Бид нийт 1'172'000 зээл олгосноороо 127тонн цаас хэмнэсэн бөгөөд дэлхийн стандартаар 1ш том модоор 10.000ш цаас хийдэг гэвэл нийтдээ 2558ш мод аварчээ. Энэ нь 100 модтой 25 жижиг цэцэрлэг байгуулах тоо юм.



Ус H2O
281'371'035 литр

1 хуудас цаас үйлдвэрлэхэд 1л ус зарцуулдаг. ЛэндМН аппликейшнээр дамжуулан зээл олгосноор 25'579'185 ширхэг цаас үйлдвэрлэхэд зарцуулагдах 281'381'035 литр усыг хэмнэжээ.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 оны II дугаар улиралд ээлжит болон ээлжит бус байдлаар 4 удаа хуралдлаа. 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар ТУЗ-ийн даргаар О.Болдбаатарыг сонгож, Нарийн бичгийн даргаар Ж.Мөнхцэцэгийг томилж, ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнийг сонголоо.

ТУЗ-ийн хурлаас гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдвал:

- Итгэлцлийн үйлчилгээний дагуу 4.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг татах эрх олгох;
- Компанийн хувьцаа халааслах ажиллагааг зохион байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох;
- Компанийн эх үүсвэрийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах гэх мэт болон 2019 оны I дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 19/12 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2019 оны Эх үүсвэрийн төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт татах ажиллагаатай холбогдуулсан бусад шийдвэрүүдийг гаргасан болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/mn>) цахим хуудаснаас харах боломжтой.

Компанийн засаглалтай холбогдох бусад нэмэлт мэдээллүүд:

- Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгов.
- Компани үйл ажиллагаа явуулах үндсэн хаягаа өөрчлөв. (Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв-д төв оффис байрлан үйл ажиллагаагаа явуулж байна)
- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлуулж, бүртгүүлэв.

Холбоо барих:

"ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Ж. Мөнхцэцэг

Утас: 99018886

Имэйл: board@lend.mn



БАЯРЛАЛАА